



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 26 өдөр

Дугаар А/803

Булган сум

Гүйцэтгэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2.1 дэх заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны XIX/08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээнд тусгасан “Хөрсний бохирдлыг бууруулах зорилгоор био жорлон” (Хутаг-Өндөр сум) нийлүүлэх нийлүүлэгчээр шалгарсан “Дансран дүвчин” ХХК-тай 79,800,000 (Далан есөн сая найман зуун мянган) төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Байгаль орчны газар (А.Гантөмөр)-т олгосугай.

2. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандарт, техникийн тодорхойлолтын дагуу нийлүүлж хүлээлгэн өгөхийг “Дансран дүвчин” ХХК-ийн гүйцэтгэх захирал (М.Бадамсүрэн)-д үүрэг болгосугай.


3. Тус хөрөнгийг холбогдох хууль, журам, гэрээний дагуу хүлээн авч, данс бүртгэлд бүртгэж хөрөнгө ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг Хутаг-Өндөр сумын Засаг дарга (О.Далайцэрэн)-д үүрэг болгосугай.

4. Гэрээнд тусгах нөхцөл шаардлагыг хавсралтаар баталж, хяналт тавин ажиллахыг хариуцсан албан тушаалтнуудад даалгасугай.

5. Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль журам, гэрээний дагуу Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Б.Бумцэнд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА


Д.ПҮРЭВ-ОЧИР



6324011183

ХАВР
МОНГОЛ

Аймгийн Засаг даргын 2024 оны
12 дугаар сарын 26-ны/ний өдрийн ... дугаар
захирамжийн хавсралт



Гэрээнд тусгагдах нөхцөл шаардлага

| Д/д | Нөхцөл шаардлага | Мөнгөн дүн | Хариуцах албан тушаалтан |
|-----|-------------------------|--|--------------------------|
| 1 | 2 | 3 | 4 |
| 1 | Алданги | Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна | Б.Бумцэнд |
| 2 | Чанарын баталгаа | 5 хувь | Б.Бумцэнд |
| 3 | Баталгаат хугацаа | 1 жил | А.Гантөмөр |
| 4 | Бараа нийлүүлэх хугацаа | Гэрээ байгуулсан өдрөөс хойш 14 хоног | А.Гантөмөр |